

ТАНИЛЦУУЛГА

*Журам батлах тухай Засгийн газрын
тогтоолын төсөл боловсруулсан тухай*

2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэлэлцэн баталсан.

Хуулийн зорилт нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийн улсын төсөвт төвлөрсөн орлогыг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн санг байгуулах, сангийн эх үүсвэр, төрөл, зориулалтыг тодорхойлох, сангийн хөрөнгийг удирдах бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 7.1.5 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг Засгийн газар батална” гэж заасан.

Дээрх хуульд заасныг үндэслэн Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх зохицуулалтыг тусгасан “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын болон журмын төсөл боловсруулав.

Энэ журмаар Монгол Улсын иргэнд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас иргэдийн эрүүл мэнд, боловсрол, орон сууцанд дэмжлэг үзүүлэх, нөхцөлийг тодорхойлох, санхүүжилт олгох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Түүнчлэн Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх тул Хуримтлалын сангийн хөрөнгийн зарцуулалт, Эрүүл мэнд, боловсрол, Орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн санхүүжилт олгох, санхүүжилт авах хүсэлт гаргах, санхүүжилт олгох ерөнхий нөхцөл, шалгуур үзүүлэлтийн талаарх нарийвчилсан зохицуулалтыг журмын төсөлд тусгалаа.

Мөн тус яам дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хариуцан ажиллах бүтцийн нэгж, шаардлагатай хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, программ хангамж шаардлагатай болно.

---oOo---